

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/7/НА-СТА-ТӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас:261885 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Аудитор: Э.Булганчимэг
Утас:263533 Цахим хаяг: bulganchimege@audit.gov.mn
Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал: Т.Одончимэг
Утас:70169029 Цахим хаяг: info@misheelodaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	12
2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	13
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	14
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	16
3.5 Эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	17
4. АУДИТЫН ТАЙЛАН	20
4.1 Ерөнхий зүйл	20
4.2 Материаллаг байдал	20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	23
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	25
5.1 Төлбөрийн акт	27
5.2 Албан шаардлага	28
5.3 Зөвлөмж	30
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	33

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АШУУИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөл
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс
ГТН	Гэрээний тусгай нөхцөл
МУИС	Монгол улсын их сургууль
НАСС	Нүүр ам судлалын сургууль
НД	Нийгмийн даатгал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОХУ	Оросын Холбооны Улс
ТББ	Тендерийн баримт бичиг
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮЭХ	Үйлдвэрчний эвлэлийн хороо
ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ACQUIN	Accreditation, Certification and Quality Assurance Institute “Магадлан итгэмжлэл, гэрчилгээжүүлэлт болон чанарын баталгаажуулалтын хүрээлэн”
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.16 № 06/705
танай _____-ны № _____-т

АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН РЕКТОР
Б.ДАМДИНДОРЖ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Архангай аймагт Хангайн бүсийн сувилахуйн сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний 2,400.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалттай цогцолборыг шинээр байгуулж, 7 хөтөлбөрөөр элсэлт авч эхэлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Сургалтын SIS программд 7 сургуулийн сургалтын төлбөрийн орлогыг бүртгэдэг боловч санхүүгийн программтай холбогдоогүй, орлого төвлөрүүлэх дансанд сургуулиудын орлогыг бүрэн төвлөрүүлээгүй зэргээс шалтгаалж сургалтын төлбөрийн үлдэгдэл санхүүгийн тайланд тусгагдсан дүнгээс зөрүүтэй байх эрсдэлтэй байна.

Тус сургуулийн дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй 14,634.8 сая төгрөгийн 5 барилгаас нүүр, ам судлалын эмнэлгийн барилга төвлөрсөн шугамд холбогдоогүйгээс улсын комисс хүлээж аваагүй, Эрхэс сувиллын барилгын ажил газрын маргаантай, хөгжлийн ордон болон спорт цогцолборын барилгын ажлууд улсын төсвийн санхүүжилт зогссон зэрэг шалтгааны улмаас тус тус зогсож, цаашид төрийн өмч хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, барилга бүрэн баригдаж дуусахгүй байх эрсдэл үүссэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд шүдний их эмч, эм зүйч, анагаах ухааны магистрын цахим хөтөлбөрүүд анх удаа олон улсын ACQUIN хөтөлбөрөөр магадлан итгэмжлэгдэж, төгсөлтийн өмнөх болон төгсөлтийн нийт 6 хөтөлбөр чанарын баталгаажуулалтыг хангаснаар Монгол Улсад төдийгүй олон улсад эмчлэх эрх бүхий эмч нар бэлтгэгдэж эхэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	38,406,930,684.66	35,789,556,498.45
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	13,145,357,894.52	14,030,127,022.34
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	268,400.00	15,501,000.00
31110	Төгрөг	268,400.00	15,501,000.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	9,415,161,695.29	8,861,166,289.46
31210	Төгрөг	7,343,563,774.99	8,282,184,659.79
31211	Төрийн сангийн харилцах	480,966,828.74	2,450,407,492.08
31213	Арилжааны банк дахь харилцах	6,862,596,946.25	5,831,777,167.71
31220	Гадаад валют	2,071,597,920.30	578,981,629.67
31223	Арилжааны банк дахь харилцах	2,071,597,920.30	578,981,629.67
31400	Замд яваа мөнгөн хөрөнгө	7,628,900.00	6,038,500.00
31500	Хадгаламж	3,722,298,899.23	5,147,421,232.88
33	АВЛАГА	12,179,207,337.92	8,043,718,699.04
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	7,542,352.78	28,357,320.20
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	3,462,990,169.40	4,400,867,335.63
33500	Бусад авлага	8,708,674,815.74	3,614,494,043.21
33510	Байгууллагаас авах авлага	8,632,897,126.30	3,583,138,983.77
33520	Хувь хүмүүсээс авах авлага	75,777,689.44	31,355,059.44
34	УРЬДЧИЛГАА	953,029,749.86	27,846,300.00
34710	Урьдчилгаа тооцоо	953,029,749.86	27,846,300.00
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	627,750,850.00	7,846,300.00
34712	Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	325,278,899.86	20,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	12,129,335,702.36	13,687,864,477.07
35100	Түүхий эд материал	9,830,878,603.04	11,453,110,660.35
35110	Тусгай зориулалттай материал	5,158,474,811.55	5,707,758,556.08
35130	Эм боох материал	4,672,403,791.49	5,745,352,104.27
35400	Хангамжийн материал	2,293,917,099.32	2,234,753,816.72
35410	Бичиг хэргийн материал	199,472,979.05	136,962,854.74
35420	Аж ахуйн материал	906,168,769.57	878,882,570.61
35430	Сэлбэг хэрэгсэл	89,050,859.41	199,887,343.00
35440	Түлш, шатах тослох материал	4,465,154.02	13,972,184.38
35450	Барилгын засварын материал	29,604,835.23	14,715,175.23
35460	Хүнсний материал	32,820,292.73	57,291,330.17
35470	Бусад хангамжийн материал	1,032,334,209.31	933,042,358.59
35600	Мал амьтад	4,540,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	317,936,055,544.70	307,354,660,376.54
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	317,936,055,544.70	307,354,660,376.54
39200	Биет хөрөнгө	297,311,613,885.61	286,616,469,078.32
39201	Барилга, байгууламж, орон сууц	241,285,991,035.72	241,888,380,157.44
39202	Хуримтлагдсан элэгдэл	(18,052,982,580.74)	(22,982,278,977.45)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,537,516,933.67	1,502,471,928.09
39204	Хуримтлагдсан элэгдэл	(808,631,209.90)	(870,830,876.39)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	109,334,089,341.93	109,124,160,898.58
39206	Хуримтлагдсан элэгдэл	(55,385,249,980.66)	(62,345,198,195.13)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,007,766,805.70	10,247,700,529.36
39208	Хуримтлагдсан элэгдэл	(6,466,785,406.43)	(6,384,292,908.54)
39209	Зам, гүүрийн байгууламж	249,623,355.88	249,623,355.88
39210	Хуримтлагдсан элэгдэл	(132,204,259.92)	(150,994,067.92)
39214	Бусад үндсэн хөрөнгө	583,981,406.13	762,845,410.13
39215	Хуримтлагдсан элэгдэл	(353,771,105.52)	(377,388,597.48)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	14,250,622,966.65	14,634,765,126.65

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн,
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

39217	Ном	1,261,646,583.10	1,317,505,295.10
39300	Биет бус хөрөнгө	20,624,441,659.09	20,738,191,298.22
39301	Програм хангамж	658,058,837.00	722,173,218.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(447,461,793.67)	(565,672,117.12)
39303	Бусад биет бус хөрөнгө	20,488,018,867.00	20,583,897,296.86
39304	Хуримтлагдсан элэгдэл	(74,174,251.24)	(2,207,099.52)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	356,342,986,229.36	343,144,216,874.99
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	11,936,150,280.19	11,770,606,203.76
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,936,150,280.19	11,770,606,203.76
41300	Өглөг	4,594,140,097.17	4,376,969,010.34
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	137,887,242.12	527,565,656.77
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	7,150,000.00	8,000,000.00
41360	Бусад өглөг	4,449,102,855.05	3,841,403,353.57
41361	Байгууллагад төлөх өглөг	4,442,054,131.05	3,831,482,342.91
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	7,048,724.00	9,921,010.66
41400	Урьдчилж орсон орлого	7,342,010,183.02	7,393,637,193.42
41420	Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого	7,104,702,393.02	2,601,551,670.16
41440	Бусад урьдчилж орсон орлого	237,307,790.00	4,792,085,523.26
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	344,406,835,949.17	331,373,610,671.23
51	Засгийн газрын хувь оролцоо	344,406,835,949.17	331,373,610,671.23
51100	Засгийн газрын оруулсан капитал	13,733,182,426.15	179,769,263,626.15
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	13,733,182,426.15	179,769,263,626.15
51200	Хуримтлагдсан үр дүн	305,545,279,950.24	116,494,232,154.40
51210	Өмнөх үеийн үр дүн	294,677,780,160.12	129,379,002,829.53
51220	Тайлант үеийн үр дүн	10,867,499,790.12	(12,884,770,675.13)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	25,128,373,572.78	35,110,114,890.68
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	356,342,986,229.36	343,144,216,874.99

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	125,285,092,139.14	109,499,141,132.58
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
110002	Үйл ажиллагааны орлого	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	84,904,121,238.14	109,499,141,132.58
120	Нийтлэг татварын бус орлого	55,887,301,787.05	106,477,298,889.35
1201	Хүүгийн орлого	491,261,414.70	379,827,598.58
120002	Бусад хүүгийн орлого	491,261,414.70	379,827,598.58
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	54,504,374,822.97	104,660,030,817.39
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,300,921,985.77	95,301,535,416.91
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,109,736,400.57	9,358,495,400.48
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	2,722,041,306.69	-
120005	Түрээсийн орлого	201,793,368.00	305,909,680.45
120009	Бусад орлого	689,872,181.38	870,802,791.93
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	8,779,019,832.63	252,571,441.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	592,655,297.31	8,156,560.00
122	Тусламжийн орлого	29,016,819,451.09	3,021,842,243.23
1221	Хандив тусламж /дотоод/	1,785,033,461.59	2,964,626,243.23
122001	Бусад хандив тусламж /дотоод/	1,785,033,461.59	2,964,626,243.23
122002	Хандив тусламж /гадаад/	27,231,785,989.50	57,216,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	40,380,970,901.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	10,304,471,000.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	75,000,000.00	-
	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,967,811,860.00	-
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	5,687,097,880.00	-
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	234,539,500.00	-
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	46,174,480.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	24,033,688,041.00	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	24,033,688,041.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	114,387,515,912.14	122,442,243,780.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	114,357,015,912.14	122,422,744,330.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	113,623,034,623.37	121,451,074,484.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	60,660,631,810.50	66,851,267,778.05
210101	Үндсэн цалин	35,202,757,349.10	39,629,773,904.22
210102	Нэмэгдэл	11,509,314,234.46	12,489,216,402.48
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,264,364,000.00	3,381,016,900.00
210104	Урамшуулал	15,407,603.50	32,427,165.60

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн,
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

210105	Гэрээт ажлын хөлс	10,668,788,623.44	11,318,833,405.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,276,441,286.39	6,920,189,926.76
210201	Тэтгэврийн даатгалын зардал	6,264,098,797.04	6,901,863,679.48
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	12,286,113.35	18,326,247.28
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	56,376.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,674,098,233.29	4,270,513,748.82
210301	Гэрэл, цахилгаан	1,658,254,814.34	2,106,113,449.72
210302	Түлш, халаалт	1,267,608,837.60	1,477,020,497.70
210303	Цэвэр, бохир ус	747,291,061.35	687,379,801.40
210304	Байрны түрээс	943,520.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	3,178,724,842.33	2,476,136,334.67
210401	Бичиг хэрэг	667,425,420.51	813,419,086.24
210402	Тээвэр, шатахуун	106,726,152.51	118,269,980.91
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	275,667,612.89	267,802,044.49
210404	Ном, хэвлэл	182,404,734.00	131,481,380.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	307,396,955.79	136,331,438.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	977,810,170.97	754,019,559.81
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	30,901,725.00	43,389,300.00
210408	Бараа материал акталсны зардал	630,392,070.66	211,423,545.22
2105	Нормативт зардал	11,993,217,044.29	12,906,998,568.27
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,368,113,607.78	12,191,450,346.21
210502	Хоол, хүнс	591,752,436.61	650,444,272.06
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	33,350,999.90	65,103,950.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,076,084,716.08	2,175,465,334.23
210601	Багаж, техник, хэрэгсэл	185,952,701.67	142,818,647.00
210602	Тавилга	71,046,461.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	621,100.00	11,697,580.00
210604	Урсгал засвар	2,818,464,453.41	2,020,949,107.23
2107	Томилолт, зочны зардал	642,612,569.52	524,850,398.80
210701	Гадаад албан томилолт	435,115,062.40	233,464,865.96
210702	Дотоод албан томилолт	166,398,029.00	259,325,751.84
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	41,099,478.12	32,059,781.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,171,678,104.06	2,643,404,729.85
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,854,923,811.84	2,307,320,117.73
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	110,106,170.00	109,784,947.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,359,830.00	1,166,724.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,419,881.00	15,611,249.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	64,000.00	1,698,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	144,814,377.50	128,084,166.94
210807	Газрын төлбөр	178,384.00	34,885,655.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	57,811,649.72	44,853,870.18

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн,
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,949,546,016.91	22,682,247,665.10
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	541,607,800.00	759,471,770.94
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,887,590,988.78	5,367,719,898.48
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	16,520,347,228.13	16,555,055,995.68
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	733,981,288.77	971,669,845.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	733,981,288.77	971,669,845.47
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	19,072,492.00	134,508,953.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	437,760,610.77	644,388,233.47
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	277,148,186.00	192,772,659.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30,500,000.00	19,499,450.00
2200	Дотоод эх үүсвэрээр	30,500,000.00	19,499,450.00
221001	Их засвар	30,500,000.00	19,499,450.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	10,897,576,227.00	(12,943,102,647.44)
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	74,734,965.31	198,979,994.01
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	74,734,965.31	198,979,994.01
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	104,811,402.19	140,648,021.70
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	59,635,096.53
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	104,811,402.19	81,012,925.17
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(30,076,436.88)	58,331,972.31
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	10,867,499,790.12	(12,884,770,675.13)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	98,526,554,072.14	110,502,270,342.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	61,265,932,752.84	110,502,270,342.60
120	Нийтлэг татварын бус орлого	61,265,932,752.84	110,502,270,342.60
1201	Хүүгийн орлого	457,920,444.15	356,143,513.67
120002	Бусад хүүгийн орлого	457,920,444.15	356,143,513.67
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	59,941,010,711.50	109,037,152,523.56
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	46,362,389,132.31	95,795,416,132.20
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,856,536,272.50	13,241,736,391.36
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	2,722,085,306.69	-
120005	Түрээсийн орлого	145,771,666.00	189,080,245.45
120009	Бусад орлого	721,229,931.19	919,894,059.92
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	37,260,621,319.30	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	15,991,568,880.00	-
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	5,687,097,880.00	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	10,304,471,000.00	-
1330	Төсвийн захирагчдаас	280,713,980.00	-
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	234,539,500.00	-
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	46,174,480.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	20,988,338,459.30	-
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	20,988,338,459.30	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	98,951,428,401.26	106,462,379,508.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	98,951,428,401.26	106,462,379,508.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	98,208,464,364.49	105,497,476,663.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	59,527,123,783.63	66,186,325,422.76
210101	Үндсэн цалин	49,458,882,181.41	55,297,237,129.25
210105	Гэрээт ажлын хөлс	10,068,241,602.22	10,889,088,293.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,148,219,943.34	7,237,764,498.13
210201	Тэтгэврийн даатгалын зардал	6,699,843,056.50	6,742,182,308.48
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	112,778,669.31	115,249,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	72,783,635.48	91,339,806.82
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	46,773,649.90	52,702,895.79
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	216,040,932.15	236,290,087.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,657,701,129.43	4,270,591,733.82
210301	Гэрэл, цахилгаан	1,650,832,854.34	2,105,117,324.72
210302	Түлш, халаалт	1,267,106,019.92	1,477,295,210.26
210303	Цэвэр, бохир ус	739,762,255.17	688,179,198.84
2104	Хангамж, бараа материалын зардал	3,598,568,718.09	2,121,782,825.90
210401	Бичиг хэрэг	580,838,852.86	490,521,216.90
210402	Тээвэр, шатахуун	99,465,649.20	168,095,960.10
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	292,670,917.03	261,700,121.90
210404	Ном, хэвлэл	266,963,683.00	123,734,604.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	286,698,776.00	243,134,488.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,071,930,840.00	834,596,435.00
2105	Нормативт зардал	10,127,806,391.39	12,193,267,144.56
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,280,125,332.39	11,355,838,378.26
210502	Хоол, хүнс	615,387,359.00	656,045,416.30
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	232,293,700.00	181,383,350.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,677,162,537.00	3,263,586,195.71
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,153,892,710.00	1,131,146,400.00

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн,
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

210602	Тавилга	113,512,660.00	97,060,950.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	24,427,700.00	400,000.00
210604	Урсгал засвар	2,385,329,467.00	2,034,978,845.71
2107	Томилолт, зочны зардал	586,361,133.32	522,464,389.58
210701	Гадаад албан томилолт	375,701,215.20	225,768,700.96
210702	Дотоод албан томилолт	170,495,456.00	262,447,807.62
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	40,164,462.12	34,247,881.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,496,380,836.85	2,921,308,536.05
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,758,817,138.14	2,333,456,806.50
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	127,222,620.00	116,268,280.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,216,830.00	15,120,722.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,364,481.00	17,379,249.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	141,000.00	209,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	591,636,622.50	396,057,727.72
210807	Газрын төлбөр	178,384.00	34,885,655.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	14,803,761.21	7,931,095.83
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,389,139,891.44	6,780,385,916.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,536,211,283.47	4,727,472,636.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,852,928,607.97	2,052,913,279.61
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	742,964,036.77	964,902,845.47
2132	Бусад урсгал шилжүүлэг	742,964,036.77	964,902,845.47
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	13,902,492.00	73,258,953.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,000,000.00	7,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	443,642,694.77	644,388,233.47
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	257,418,850.00	240,255,659.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(424,874,329.12)	4,039,890,834.02
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	11,726,767,678.10	3,273,088,774.45
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,726,767,678.10	3,273,088,774.45
2200	Дотоод эх үүсвэрээр	11,726,767,678.10	3,273,088,774.45
220001	Барилга байгууламж	5,784,358,065.00	243,300,000.00
221001	Их засвар	2,779,886,581.10	694,731,845.45
222001	Тоног төхөөрөмж	2,840,420,392.00	1,254,433,750.00
223001	Бусад хөрөнгө	199,400,000.00	128,212,869.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	122,702,640.00	952,410,310.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(11,726,767,678.10)	(3,273,088,774.45)
14	Бусад эх үүсвэр	-	117,967,068.25
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	117,967,068.25
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	30,076,436.88	-
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	30,076,436.88	-
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(30,076,436.88)	117,967,068.25
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(12,181,718,444.10)	884,769,127.82
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	25,327,076,338.62	13,145,357,894.52
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,145,357,894.52	14,030,127,022.34

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

Код	Дансны нэр, төрөл	<i>/төгрөгөөр/</i>			
		1.1 Засгийн газрын оруулсан капитал	1.2 Дахин үнэлгээний нөөц	1.3 Хуримтлагдсан үр дүн	1.4 Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,733,182,426.15	25,128,373,572.78	296,331,169,754.70	335,192,725,753.63
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(1,653,389,594.58)	(1,653,389,594.58)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,733,182,426.15	25,128,373,572.78	294,677,780,160.12	333,539,336,159.05
9	Тайлант үеийн үр дүн	-	-	10,867,499,790.12	10,867,499,790.12
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,733,182,426.15	25,128,373,572.78	305,545,279,950.24	344,406,835,949.17
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	166,036,081,200.00	677,105,666.52	(176,166,277,120.72)	(9,453,090,254.20)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	179,769,263,626.15	25,805,479,239.30	129,379,002,829.52	334,953,745,694.97
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	9,304,635,651.38	0.01	9,304,635,651.39
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(12,884,770,675.13)	(12,884,770,675.13)
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	179,769,263,626.15	35,110,114,890.68	116,494,232,154.40	331,373,610,671.23

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2024 оны гүйцэтгэл	2025 оны		Зөрүү	Хувь
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	НИЙТ ОРЛОГО	125,285,092.1	117,136,155.4	109,238,413.1	(7,897,742.3)	93.3
120	Нийтлэг татварын бус орлого	84,904,121.2	114,720,253.8	106,216,570.9	(8,503,682.9)	92.6
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	45,132,699.7	98,540,622.7	95,301,535.4	(3,239,087.3)	96.7
1200042	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	10,754,602.1	16,179,631.1	10,915,035.5	(5,264,595.6)	67.5
122	Тусламжийн орлого	29,016,819.4	2,415,901.6	3,021,842.2	605,940.6	125.1
13	Тусламж, санхүүжилтийн орлого	40,380,970.9	-	-	-	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	10,304,471.0	-	-	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	75,000.0	-	-	-	-
1330	Төсвийн захирагчдаас	5,967,811.9	-	-	-	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	24,033,688.0	-	-	-	-
2	НИЙТ ЗАРДАЛ	114,387,515.9	111,676,521.2	122,442,243.8	10,765,722.6	109.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	60,660,631.8	70,019,472.6	66,851,267.8	(3,168,204.8)	95.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,276,441.3	7,075,615.1	6,920,189.9	(155,425.2)	97.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,674,098.2	5,493,299.6	4,270,513.8	(1,222,785.8)	77.7
2104	Хангамж, бараа материалын зардал	3,178,724.8	2,264,086.4	2,476,136.3	212,049.9	109.4
2105	Нормативт зардал	11,993,217.0	13,381,068.8	12,906,998.6	(474,070.2)	96.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,076,084.7	3,152,401.6	2,175,465.3	(976,936.3)	69.0
2107	Томилолт, зочны зардал	642,612.6	717,473.0	524,850.4	(192,622.6)	73.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,171,678.1	3,578,756.7	2,643,404.7	(935,352.0)	73.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,949,546.0	4,451,774.7	22,682,247.7	18,230,473.0	509.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	733,981.3	1,542,572.4	971,669.8	(570,902.6)	63.0
220	Хөрөнгө зардал	30,500.0	-	19,499.5	19,499.4	-
3	Үр дүн	10,867,499.8	-	(13,203,830.7)	(13,203,830.7)	-
4	Нийт ажиллагсад	1,460.0	1,587.0	1,550.0	(37.0)	97.7
5	Цалингийн сан	60,660,631.8	70,019,472.6	66,851,267.8	(3,168,204.8)	95.5
6	Нийт авлага	12,179,207.3	-	8,043,718.7	8,043,718.7	-
7	Нийт өр төлбөр	11,936,150.3	-	11,770,606.2	11,770,606.2	-
8	Нийт хөрөнгө оруулалт	11,726,767.7	5,459,634.2	3,273,088.8	(2,186,545.4)	60.0
9	Үүнээс өөрийн хөрөнгөөр	11,726,767.7	5,459,634.2	3,273,088.8	(2,186,545.4)	60.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль нь 1942 онд МУИС-ийн дэргэдэх “Хүн эмнэлгийн факультет” нэртэйгээр 4 тэнхим, 34 оюутантайгаар анх байгуулагдсан.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль нь “Дэлхийн шилдэг сургуулийн нэг болох” зорилготой алсын харааг тодорхойлон, “Эрдэм шинжилгээ, сургалт, эрүүл мэндийн чанартай тусламж үйлчилгээ үзүүлдэг, олон улсын хэмжээнд манлайлагч их сургууль байх” зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

Тус сургууль нь “Бидний бүтээсэн түүх, оюуны бүтээл, нэр хүнд, эв нэгдэл, Эрдэм мэдлэг, ёс зүйтэй, чадварлаг багш судлаач, эмч нар, Эрдэмд шамдагч, эрүүл чийрэг, эрч хүчтэй оюутан залуус, Бүтээлч манлайлагч төгсөгчид гэж үнэт зүйлээ тодорхойлсон байна.

Тус сургуулийн дүрэмд үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Эрдэм шинжилгээ сургалт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх;
- Их сургуулийн эрдэмтэн, багш, судлаач, эмч эмнэлгийн мэргэжилтэн, ажилтныг чадавхжуулах;
- Анагаах ухааны боловсрол олгох бүх шатны сургалтын үйл ажиллагаанд оролцоно;
- Төгсөлтийн өмнөх, төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагаа явуулна;
- Иргэдэд эрүүл мэндийн боловсролыг олгох, эрүүл амьдралын хэвшил тогтоох нөлөөллийн үйл ажиллагаа явуулна;
- Олон улсын байгууллага, эмнэлгүүдийн холбоонд нэгдэх, төр хувийн хэвшлийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллана гэж тодорхойлжээ.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль нь бүрэлдэхүүн 7 сургууль, орон нутаг дахь харьяа 4 сургууль болон лицей сургуулиудад 11829 оюутан суралцагчидтай, эмнэлэг 4, сувилал 2, эрдэм шинжилгээний хүрээлэн 3, эмнэлзүй молекул оношилгооны төв, судалгааны бусад нэгжүүдийн 1550-аад эрдэмтэн багш, ажиллагсадтайгаар сургалт, эрдэм шинжилгээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж тайлант онд 109,520.0 сая төгрөгийн орлоготой ажилласан монгол улсын эрдэм оюуны томоохон төв байна.

Тус сургуулийн дүрэмд зааснаар өмчийг 100 хувь төр эзэмшиж байгаа бөгөөд төрийн өмчийн төлөөллийг Засгийн газраас эрх олгосноор Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар хэрэгжүүлэхээр заасан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийг ЭМШУИС-ийн Удирдах зөвлөлийн хурлын 2014 оны 2 дугаар сарын 21-ны өдрийн 005 тоот тогтоол, БСШУ-ны сайдын 2014 оны 4 дүгээр сарын 09-ний өдрийн А/134 тоот тушаалыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах” гэсэн заалттай нийцэж байна.

Дээд боловсролын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.7-д “нээлттэй сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн дээд боловсролын сургалтын байгууллагын

гүйцэтгэх удирдлагыг 5 жилийн хугацаагаар томилж, гэрээ байгуулах, хуульд заасан үндэслэлээр чөлөөлөх” гэж заасны дагуу Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн ректорыг Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилж байна.

Тус сургууль нь Боловсролын ерөнхий хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Шинжлэх ухаан, технологийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд их сургуулийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам;
- Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дотоод журам;
- Төгсөлтийн өмнөх сургалтад оюутан элсүүлэх журам;
- Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох журам;
- Галын аюулгүй байдлын дүрэм;
- Авлига ашиг сонирхлын эсрэг журам.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод хяналт шалгалтын алба нь Дотоод хяналт шалгалтын албаны ажиллах журмыг баримтлан, албаны дарга, төсөв санхүү, төсөл эрдэм шинжилгээ хариуцсан дотоод аудитор 2, хууль тогтоомж тушаал шийдвэр, тайлан төлөвлөгөө, биелэлт дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн 2 нийт 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байна. Санхүүгийн дотоод хяналтын нэг ажилтантайгаас шалтгаалан хяналт хангалтгүй хийгддэг, хараат бус байдалд нөлөөлөх эрсдэлтэй, санхүүгийн ажилтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, ур чадварыг сайжруулах арга хэмжээ авч ажилладаггүйгээс санхүүгийн албаны үйл ажиллагаанд алдаа, зөрчил ихээхэн гарсан буюу дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус сургууль нь Боловсрол шинжлэх ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдлөг болгон үйл ажиллагаандаа ашигладаг.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, боловч шинээр гарсан дүрэм, журмыг тусгаагүй, эрүүл мэндийн үйлчилгээтэй зохицсон тусгай бодлого байхгүй, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 “Аж ахуйн нэгж байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль, тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2025 оны санхүүгийн тайлант Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 13,198.8 сая төгрөгөөр буюу 3.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	13,145,357.9	14,030,127.0	884,769.1
Авлага	12,179,207.3	8,043,718.7	(4,135,488.6)
Урьдчилгаа тооцоо	953,029.8	27,846.3	(925,183.5)
Бараа материал	12,129,335.7	13,687,864.5	1,558,528.8
Үндсэн хөрөнгө	317,936,055.5	307,354,660.4	(10,581,395.1)
Нийт хөрөнгө	356,342,986.2	343,144,216.9	(13,198,769.3)
Өр төлбөр	11,936,150.3	11,770,606.2	(165,544.1)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	344,406,835.9	331,373,610.7	(13,033,225.2)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	356,342,986.2	343,144,216.9	(13,198,769.3)

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэлд нөлөө бүхий дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 884.8 сая төгрөгөөр өссөн нь 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр татаас санхүүжилтийн орлогыг хүлээн авсан мөн эмнэлгийн тусламж үйл ажиллагааны орлого нэмэгдсэнтэй холбоотой.

Авлага дансны үлдэгдэл 4,135.5 сая төгрөгөөр буурсан нь ЭМДС-аас хүлээн авах төлбөртэй үйлчилгээний авлагын үлдэгдэл буурсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

Бараа материал дансны үлдэгдэл 1,558.5 сая төгрөгөөр өссөн нь томуу, томуу төст өвчний дэгдэлт болон яаралтай тусламжийн үед шаардагдах нөөцийг нөхөн бүрдүүлсэнтэй холбоотойгоор эм эмнэлгийн хэрэгсэл, болон бусад бараа материалын худалдан авалт нэмэгдсэн.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 10,581.4 сая төгрөгөөр буурсан нь 5,239.8 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан мөн хандиваар АШУҮИСургууль 56.9 сая төгрөг, Анагаах ухааны сургууль 27.4 сая төгрөг, АШУҮИС-ийн Дундговь аймаг дахь салбар сургууль 20.9 сая төгрөг, АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлэг 2,736.7 сая төгрөг нийт 2,841.9 сая төгрөгийн хөрөнгийг хүлээн авснаар нэмэгдэж, 4,610.1 сая төгрөгийн

хөрөнгө акталж, 12,103.5 сая төгрөгийн тайлант хугацааны элэгдлийн зардлаар буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 165.5 сая төгрөгөөр буурсан нь өмнөх хугацаанд үүссэн бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын хуримтлагдсан өр төлбөрийг төлж барагдуулсантай холбоотой.

Улсын төсвийн оруулсан хөрөнгө дансны үлдэгдэл 166,036.1 сая төгрөгөөр өссөн нь Монгол-Японы эмнэлгийн барилгын дүнгээр өссөн байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 13,033.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны хуримтлагдсан үр дүнгээр буурсан байна.

Тус газрын санхүүгийн тайланд 646.1 сая төгрөгийн дараах хэрэглээний програмууд бүртгэлтэй байна. Үүнд:

- Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 365.4 сая төгрөгийн Юникус програм, 3.6 сая төгрөгийн Виница програм, 0.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн програм;
- Хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой 43.2 сая төгрөгийн ERP програм;
- Хүний нөөц хөгжлийн албаны бичиг хэрэг удирдлагын 4.9 сая төгрөгийн програм;
- Шилдэг шалгаруулах 6.8 сая төгрөгийн дэд системийн төвийн програм хангамж;
- Төсөл, эрдэм шинжилгээний төвийн 15.4 сая төгрөгийн CSO програм хангамж;
- Хяналтын хамгаалалтын 4.2 сая төгрөгийн лиценз;
- Эмчийн үзлэгийн цаг болон төлбөр төлөлтийн 0.6 сая төгрөгийн програм;
- Лабораторийн бүртгэлийн 6.5 сая төгрөгийн програм;
- Сургалтын төлбөрийн 4.5 сая төгрөгийн мэдээллийн програм;
- Элсэлтийн оюутны 12.0 сая төгрөгийн бүртгэлийн програм;
- Гадаад хэлний хичээлийн 6.1 сая төгрөгийн програм;
- Компьютер томографын 93.4 сая төгрөгийн програм;
- Дүрс оношилгооны 6.9 сая төгрөгийн лиценз;
- Камерын хяналтын 48.3 сая төгрөгийн нэгдсэн систем, камерын хяналтын 1.1 сая төгрөгийн үндсэн системийн лиценз;
- Олон нийтийн мэдээллийн 6.7 сая төгрөгийн веб сайт;
- Workstation дээр ажиллах компьютер томографын 15.6 сая төгрөгийн хангамжийн програмууд тус тус бүртгэлтэй байна.

Дээрх програм хангамжуудад жилийн ашиглалтын зардалд 63.4 сая төгрөгийн төлбөр төлдөг байна.

3.5 Эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Боловсролын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1, Дээд боловсролын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.1.2, 27.1.4, 27.1.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь заалтын дагуу Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн төсвийн төлөвлөгөөг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулж, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 29,170.9 сая төгрөг, сургалтын төлбөрийн орлого 70,425.7 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 13,239.4 сая төгрөг нийт 112,836.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг Удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны 14 дүгээр тогтоолоор 112,836.0 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь хангамж бараа

материалын зардал болон нормативт зардлыг батлагдсан орон тоо, норм, оюутны элсэлтийн төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөсөнтэй холбоотой өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 4,300.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж 117,136.2 сая төгрөгөөр тодотгосон байна. Энэ нь эрүүл мэндийн даатгалын санхүүжилтийг 4,222.7 сая төгрөг, үйл ажиллагааны бус орлогыг 1,141.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж сургалтын төлбөрийн орлогыг 1,063.8 сая төгрөгөөр бууруулан 111,676.5 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, үйл ажиллагааг санхүүжүүлэхээр тооцож төлөвлөсөн байна.

3.5.2 Эдийн засгийн зорилтот түвшний гүйцэтгэл

Гүйцэтгэлээр сургалтын төлбөрийн орлого 95,301.5 сая төгрөг, үндсэн бус үйл ажиллагааны орлого 10,915.0 сая төгрөг, тусламжийн орлого 3,021.8 сая төгрөг нийт 109,238.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 122,442.2 сая төгрөг буюу 109.6 хувьтай байгаа нь бараа ажил үйлчилгээний нийт зардал 11,336.7 сая төгрөгөөр илүү, урсгал шилжүүлэг 571.0 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардал 2,187.6 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Үзүүлэлт	2025 он		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	НИЙТ ОРЛОГО	117,136.2	109,238.4	(7,897.8)	93.3
1.2	Үндсэн үйл ажиллагааны орлого	98,540.6	95,301.5	(3,239.1)	96.7
1.2	Үндсэн бус үйл ажиллагааны орлого	16,179.6	10,915.0	(5,264.6)	67.5
1.3	Тусламжийн орлого	2,415.9	3,021.8	605.9	125.1
2	НИЙТ ЗАРДАЛ	111,676.5	122,442.2	10,765.7	109.6
2.1	Бараа ажил үйлчилгээний зардал	110,133.9	121,470.6	11,336.7	110.3
2.2	Урсгал шилжүүлэг	1,542.6	971.6	(571.0)	63.0
3.1	Хөрөнгө оруулалтын зардал	5,459.7	3,272.1	(2,187.6)	59.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Тухайлбал:

- Тус сургууль болон харьяа эмнэлгүүд нь тайлант онд төрийн албан хаагчийн 9 хувийн орон тооны цомхотголыг хэрэгжүүлээгүй.
- АШУҮИС болон ҮЭХ-ны 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хамтын гэрээгээр ажлын нэг өдрийн хоолны нөхөх төлбөрийг 4.0 мянган төгрөгөөр, унааны нөхөх төлбөрийг 6.0 мянган төгрөгөөр баталсан.
- Тайлант онд гадаад томилолтын зардалд 248.7 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 225.8 сая төгрөг зарцуулж, АШУҮИС-ийн

төлөөлөгчид АНУ-д 1, ОХУ-д 3, БНСУ-д 5, БНХАУ-д 3, Япон улсад 2, Австрали улсад 1, Тайланд улсад 1, ХБНГУ-д 1 нийт 17 удаагийн гадаад албан айлчлал хийсэн байна. Албан айлчлалын хүрээнд багш, эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэргэжил дээшлүүлэх богино, дунд, урт хугацааны сургалтад хамруулах, хүний нөөцийг чадавхжуулах, шинэ технологи нэвтрүүлэх, хөрөнгө оруулалт, хамтарсан судалгааны ажлуудыг эхлүүлэх зорилгоор хамтын ажиллагааны санамж бичиг, гэрээ байгуулсан. Гадаад хамтын ажиллагааны хүрээнд 6 багш докторын, 2 багш магистрын, 3 оюутан бакалаврын бүрэн тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдсан ба нийт 160 гаруй оюутнуудыг соёлын, академик, эмнэлзүйн дадлага хийх солилцооны хөтөлбөрт хамруулсан.

- Тайлант онд хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 2,356.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 2,072.2 сая төгрөгийг зарцуулсан байна. Тус зардалд оюутны хээрийн дадлага, улсын шалгалтын ажлын хөлс, гардан шалгалтын бүх зардал, зуны хээрийн дадлага, магадлангийн төлбөр хураамжаас бусад бүх зардал, эмийн лабораторид ашиглагдах урвалж бодисын зардал, НАСС-ийн шүдний багаж хэрэгслийн зардлууд багтдаг байна.
- Тайлант онд хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ байгуулаагүй, төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй байна.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн тогтоолоор баталсан Төсвийн дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 51 бараа, ажил, үйлчилгээг 13,298.9 сая төгрөгөөр худалдан авахаар баталж, гүйцэтгэлээр 23 тендерийг санхүүжилтээс хамааран явуулаагүй, нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авах 501.3 сая төгрөгийн 2 барааг шууд гэрээ байгуулсан, 180.0 сая төгрөгийн 1 тендер амжилтгүй болж, 4,623.9 сая төгрөгийн 19 гэрээг байгуулан, 34.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Мишээл-Од Аудит ХХК-ийн ахлах аудитор М.Цэнд-Аюуш, аудитор П.Энхцэлмэг, Б.Цогзолмаа, О.Цэндхүү нар гүйцэтгэж, гүйцэтгэх захирал Т.Одончимэг, Чанарын хяналтын менежер Э.Энхцэцэг нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүүгийн аудитын газрын аудитор Э.Булганчимэг, аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2026 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 01/106 дугаарын албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 114,492.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 1,144.9 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Төсвийн зардлыг батлагдсан хуваарийн дагуу сахилга баттай зарцуулж, урсгал зардлыг бууруулан, гадаад болон дотоод томилолтын зардлыг хэмнэсэн. Мөн эмнэлгийн ачаалал өмнөх оноос ихэссэн боловч орон тоонд өөрчлөлт оруулалгүйгээр давхар үүрэг гүйцэтгэх зохион байгуулалт хийж ажилласан. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шаардлагад нийцүүлэн тансаг хэрэглээ, шаардлагагүй арга хэмжээний зардлыг танаж, төсвийн сахилга батыг сайжруулахад анхаарч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 13,273.7 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт: Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6,193.3 сая төгрөгийн орлогын 100 гүйлгээ, 7,044.7 сая төгрөгийн зарлагын 145 гүйлгээг мэдээлээгүй, өмнөх оны аудитаар хүргүүлсэн 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 499/A0150053 дугаар албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралт “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.10-т “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд иж бүрэн, үнэн зөв байршуулж, зөрчлийг давтан гаргахгүй байх, өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй ажилтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт 1: Тендерт шалгарсан 7 оролцогчтой 1,189.8 сая төгрөгийн гэрээ байгуулахдаа 35.7 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгаа гаргуулан аваагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 “Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Гүйцэтгэлийн баталгаа гаргуулан аваагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл хөтлөх, тендерийг үнэлэх, мэдэгдэл хүргүүлэхдээ холбогдох журам, заалтыг мөрдөж ажиллаагүй, тендерийн баримт бичгийг архивын нэгж үүсгэхдээ шалгарсан оролцогчийн тендерийн баримт бичгийг хавсаргаагүй, тендерт шалгараагүй оролцогчдын нэг ижил баримт

материалыг их хэмжээгээр хувилж хавсарган бичиг хэргийн үргүй зардал гаргасан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.4 "цахим гарын үсэг, цахим шуудан ашиглах зэргээр албан бичиг боловсруулах, илгээх үйл явцыг хялбаршуулж бичгийн цаас, хувилагч, хэвлэгчийн хор, шуудан хүргэлтийн зардлыг хэмнэх" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулж, бичиг хэргийн үргүй зардал гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчлүүд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 улирлын санхүүгийн тайланг хамруулж, өмнөх оны зөвлөмжийн биелэлт, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, цалин хөлс, татварын бүртгэл, сургалтын SIS програмын бүртгэл, өглөг, авлагын данстын горим, сорил хэрэгжүүлсэн.

Аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулж, асуудлын бүртгэлээр баталгаажууллаа. Завсрын аудитаар 133,217.9 сая төгрөгийн 17 алдааг залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар 40.8 сая төгрөгийн зөрчилд 5 төлбөрийн акт, 694.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах 5 албан шаардлага, зөрчлийг давтан гаргахгүй байх 272.8 сая төгрөгийн 3 зөвлөмж өгснөөс тайлант онд 4 албан шаардлага, 2 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	5	40,817.2	5	40,817.2	100.0
Албан шаардлага	5	694,071.9	1	-	25.0
Зөвлөмж	3	272,781.8	1	11,018.0	33.3
Нийт дүн	13	1,007,670.9	7	51,835.2	53.8

Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмж хэрэгжээгүй дараах зөрчлүүд байна.Үүнд:

1. Өмнөх оны аудитаар өгөгдсөн "түрээсийн гэрээний үүргийн биелэлтийг тухай бүр дүгнээгүйгээс 80.0 сая төгрөгийн түрээсийн төлбөрийг огт аваагүй" гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант онд 162.1 сая төгрөгийн түрээсийн үйлчилгээний зөрчил гаргасанд зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв;
2. Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6,193.3 сая төгрөгийн орлогын 100 гүйлгээ, 7,044.7 сая төгрөгийн зарлагын 145 гүйлгээг мэдээлээгүй, 20,085.3 сая төгрөгийн орлогын 173 гүйлгээ, 32,516.1 сая төгрөгийн зарлагын 393 гүйлгээг

- хугацаа хоцроож, бусад 66 мэдээллийг мэдээлээгүй, 8 мэдээллийг хугацаа хоцроосон, өмнөх оны аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.
3. Өмнөх аудитаар хүргүүлсэн "Ажил гүйцэтгэх гэрээгээр олгосон цалин хөлснөөс НДШ суутган төсөвт төвлөрүүлж ажиллах" гэсэн албан шаардлагын хэрэгжилтийг шалгахад хөлсөөр ажиллах гэрээгээр олгосон 38.9 сая төгрөгийн ажлын хөлсөнд НДШ тооцоогүй, шимтгэлийг тайлагнаагүй буюу хэрэгжилт хангалтгүй байгаа зөрчлийг арилгах хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв;
 4. Өмнөх оны аудитаар хүргүүлсэн шууд худалдан авалт хийсэн тухай албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайланд онд нээлттэй тендер сонгон шалгаруулах 365.0 сая төгрөгийн худалдан авалтад шууд гэрээ байгуулсан зөрчлийг давтан гаргасанд зөрчлийг арилгах хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв;
 5. Өмнөх оны аудитаар хүргүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж, холбогдох журмын дагуу тендерийн үнэлгээг хийгээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд түүврээр 4 тендерийн баримт бичигт хяналт хийхэд үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл гарын үсгээр баталгаажуулаагүй, батлагдсан тендерийн баримт бичигт гэрээний тусгай нөхцлийн маягтын мэдээллийг бөглөөгүй, өгөгдлийн хүснэгтэд ижил төстэй гэрээний үнийн дүн төсөвт өртгийн үнийн дүнгээс багагүй гэж заасан шалгуур, хүний нөөцийн шаардлага болох ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан 5 ба түүнээс дээш гэж заасан шалгуур тус тус хангаагүй оролцогчдыг шалгаруулсан, шалгарсан оролцогчдод мэдэгдэл хүргүүлэхдээ 2 аж ахуйн нэгжид шалгарсан тухай мэдэгдлийг хүргүүлсэн, бараа нийлүүлэх багц 1 болон 3-д шалгарсан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахдаа ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг хавсаргасан зэрэг зөрчлийг давтан гаргасанд зөрчлийг арилгах хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв;
 6. Худалдан авалтын зарлагын гүйлгээнээс түүвэрт хамруулан цахим төлбөрийн баримттай тулган баталгаажуулахад 76 харилцагчийн 264.5 сая төгрөгийн гүйлгээ төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу өмнөх аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй байгаад албан шаардлага хүргүүлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн анхаарал татсан дараах асуудлуудад дараагийн аудитаар горим сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Үүнд:

- Сургалтын "SIS" программд 7 сургуулийн сургалтын төлбөрийн орлогыг бүртгэдэг боловч санхүүгийн программтай холбогдоогүй, орлого төвлөрүүлэх дансанд сургуулиудын орлогыг бүрэн төвлөрүүлээгүй зэргээс шалтгаалж сургалтын төлбөрийн үлдэгдэл санхүүгийн тайланд тусгагдсан дүнгээс зөрүүтэй байх эрсдэлтэй байна;
- Сургуулийн харьяа 4 эмнэлгийн эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр авахаар нэхэмжилсэн санхүүжилтээс шинжилгээ оношилгооны бүрдэл дутуу, өвчтөн эмнэлгийн тусламж үйлчилгээ авч байх явцдаа өөр эмнэлгээр үйлчлүүлсэн, өвчний түүхийн бичилт шаардлага хангаагүй зэрэг зөрчилтэй асуудлаас шалтгаалан тусламж үйлчилгээний чанарын хяналтаар

- авлага буурч, байгууллагыг хохироох үйлдэл дахин давтагдаж байгаа эсэхийг анхаарах;
- Дуусаагүй барилга, байгууламж дансанд бүртгэлтэй дутуу баригдсан барилгын санхүүжилт, гүйцэтгэлийн талаар дараагийн аудитаар анхаарах асуудалд орууллаа.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 761.4 сая төгрөгийн 13 алдаа¹ илэрсэнд аудитын явцад 739.3 сая төгрөгийн 8 алдааг залруулж, 22.1 сая төгрөгийн 5 алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

- Санхүү байдлын тайлангийн эргэлтийн хөрөнгийн эхний үлдэгдлийн дүн 2024 оны аудитлагдсан тайлангаас 6.7 сая төгрөгөөр зөрүүтэй;
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн хандив, тусламжийн орлогын ангилалд тайлагнах 122.7 сая төгрөгийг нийтлэг татварын бус орлогын ангилалд тайлагнасан;
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх ангилалд тайлагнах 0.4 сая төгрөгийг банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж ангилалд тайлагнасан;
- Санхүүгийн үр дүнгийн тайлангийн төрөөс иргэдэд олгох нэг удаагийн тэтгэмж, урамшуулал ангилалд тайлагнах 7.0 сая төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал ангилалд тайлагнасан;
- Мөнгөн гүйлгээний тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилт ангилалд тайлагнах 352.8 сая төгрөгийг улсын төвлөрсөн төсөв ангилалд тайлагнасан;
- Санхүүгийн үр дүнгийн тайланд тусгагдсан элэгдэл, хорогдлын дүн үндсэн хөрөнгийн тодруулга тайлангаас 247.0 сая төгрөгөөр зөрүүтэй;
- Санхүү байдлын тайланд тусгагдсан нийт хөрөнгийн дүн өмчийн өөрчлөлтийн тайлангаас 2.1 сая төгрөгөөр зөрүүтэй;
- Санхүү байдлын тайланд тусгагдсан цэвэр хөрөнгө, өмчийн дүн өмчийн өөрчлөлтийн тайлангаас 0.5 сая төгрөгөөр зөрүүтэй зэрэг нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 1.27-т Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой гэсэн заалттай нийцээгүй байсныг залруулсан.

Залруулаагүй алдаа:

Илрүүлэлт 1: Эрдэмтэн, судлаачдын бүтээсэн бүтээлүүдийг Оюуны өмчийн газарт бүртгүүлэн зохиогчийн эрх, патентыг авсан боловч эдгээрийг биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгээгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2 "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Оюуны өмчийн газарт бүртгүүлж, данс бүртгэлд тусгах.

Илрүүлэлт 2: Тайлант онд 3.5 сая төгрөгийн үнэ бүхий сагсны өмсгөл, гар бөмбөгийн хувцас, халаалтын цамц худалдан авсан;

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 8.1 "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг баримтлан, спорт болон тэмцээн уралдаантай холбоотой зардал гаргахгүй байх.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Илрүүлэлт 3: Газар эзэмших эрхийн хугацаа дууссан 2 гэрчилгээний хугацааг сунгаагүй;

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 3 дугаар зүйлийн 3.8 "Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газар эзэмших гэрчилгээний хугацааг сунгуулж, шинэчлэх.

Илрүүлэлт 4: Баталгаажсан цалингийн хүснэгтийг нийгмийн даатгалын тайлан, ХХОАТ-ын тайлантай тулган шалгахад 2 сургуулийн нийгмийн даатгалын тайланг 4.0 сая төгрөгөөр, 1 эмнэлэг, 2 сургуулийн ХХОАТ-ын тайланг 13.1 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан. Мөн татварын хөнгөлөлтийн тооцооллыг хийгээгүйгээс 2 сургууль 1.6 сая төгрөгийн хөнгөлөлтийг дутуу тооцсон;

Энэ нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Ажил олгогч болон энэ хуулийн 7.2, 7.3, 7.4, 7.5-д заасан даатгуулагч дараах хувь хэмжээгээр сар бүр нийгмийн даатгалын шимтгэл төлнө:", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1 "Энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;", 23 дугаар зүйлийн 23.1 "Албан татвар төлөгчийн энэ хуулийн 7.1.1, 7.1.2, 7.1.3, 7.1.4, 7.1.5, 7.1.7-д заасан орлогод ногдуулах жилийн албан татварт дараах хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлүүлнэ:" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын тайлан болон ХХОАТ-ын тайланг цалингийн хүснэгтийн дагуу үнэн, зөв тайлагнах.

Илрүүлэлт 5: Санхүүгийн албаны удирдлага, зохион байгуулалтад тавих хяналт сул, ажилтнуудын ажлын ачаалал тэнцвэргүй, санхүүгийн дотоод хяналтын нэг ажилтантайгаас шалтгаалан дотоод хяналт хангалтгүй хийгддэг, ажилтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, ур чадварыг сайжруулах арга хэмжээ авч ажилдаггүй зэргээс шалтгаалан санхүүгийн албаны үйл ажиллагаанд алдаа, зөрчил ихээхэн гарсан буюу дотоод хяналт сул, хангалтгүй байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.2 "чиг үүрэг, орон тоог давхардуулан тогтоох", 15.2.6 "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөлсийг орлого, гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох", 19 дүгээр зүйлийн 19.2 "Төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан энэ хуульд заасан хангамж, үйл ажиллагааны хязгаарлалтыг чанд мөрдөх ажилд хяналт тавьж, удирдах ажлыг хэрэгжүүлнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүү, эдийн засгийн газрын бүтэц зохион байгуулалтыг оновчтой төлөвлөх, санхүүгийн дотоод хяналтыг сайжруулж, алдаа зөрчлийг арилгах.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн санхүүгийн зөрчил

Аудитаар нийт 1,116.4 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил² илэрснээс 9.7 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 403.9 сая төгрөгийн 3 зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага, 513.0 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 167.7 сая төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгч, залруулагдаагүй 5 алдаанд 22.2 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 1,116.4 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 1,144.9 сая төгрөгөөс бага байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт 1: Тайлант онд “Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох журам”-ын дагуу цалин хөлсийг олгохдоо 4 сургуулийн 6 багшид 2.5 сая төгрөгөөр батлагдсан тушаалаас илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалин хөлсийг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

Илрүүлэлт 2: Ээлжийн амралтын хоног болон ажлын хоногийг давхардуулан тооцож, 2 сургуулийн 3 албан хаагчид 0.6 сая төгрөгийн цалин хөлсийг илүү олгосон, мөн 2024 онд ажлаас чөлөөлөгдсөн 5 багшийн ажилласан хугацааны цалинд 6.5 сая төгрөгийг тайлант оны 6 дугаар сард тооцож олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 “Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалин хөлсийг буруутай этгээдээр нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Албан шаардлага

Илрүүлэлт 1: Худалдан авалтын зарлагын гүйлгээнээс түүвэрт хамруулан цахим төлбөрийн баримттай тулган баталгаажуулахад 76 харилцагчийн 264.5 сая төгрөгийн гүйлгээ төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, өмнөх аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтыг төлбөрийн баримтаар иж бүрэн баримтжуулахгүй байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2: Цайны газрын зориулалттай 2 сургуулийн 581.2 м² талбайг 2023 оноос эхлэн нэр бүхий нэг харилцагчид түрээсийн гэрээгээр ашиглуулсан боловч түрээсийн төлбөр аваагүй, 2023 онд засварын ажилд зарцуулсан гэх нотлох баримтын бүрдэлгүй 75.0 сая төгрөгийг түрээсийн төлбөрт тооцуулах хүсэлт гаргасныг тус сургуулийн ректорын 2025 оны А/231 дугаар тушаалаар тайлант онд түрээсийн төлбөрт тооцон, зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Мөн 89.0 сая төгрөгийн 145 ширхэг цайны газрын зориулалттай шинэ хөрөнгийг ашиглуулж байгаа боловч гэрээний хавсралтад тусгаагүй, өмнөх оны аудитаар өгсөн “Төрийн өөрийн өмчийн хөрөнгийг түрээслүүлэх гэрээний үүргийн биелэлтийг хангаж ажиллах” зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, ТӨБЗГ-ын “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах” тухай 2020 оны 49 дүгээр тогтоолын хавсралтын 4 “Төрийн өмчийн бүртгэлд байгаа барилга байгууламжид түрээслэгчийн санхүүжилтээр урсгал засвар хийх тохиолдолд түрээсийн төлбөрөөс суутган тооцох асуудлыг засвар хийхээс өмнө ТӨБЗГ-т тавьж шийдвэрлүүлнэ”, Түрээсийн гэрээний 1.6 “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгөнд зөвшөөрөлгүйгээр хөрөнгө оруулалт хийхийг хориглох, зайлшгүй тохиолдолд ТӨБЗГ-аас зөвшөөрөл авах бөгөөд зөвшөөрөлгүй хөрөнгө оруулалт, их засвар хийсэн тохиолдолд зардлыг төрөөс хариуцахгүй”, 6.4 “Түрээсэлсэн эд хөрөнгөнд түрээслэгч урсгал зардлыг өөрийн хөрөнгөөр хийж болно. Урсгал засвар гэдэгт барилгын их засвар хооронд барилга ашиглалтыг сайжруулахаар хийгдэж буй засварыг ойлгоно, Урсгал засварыг түрээсийн төлбөрт суутган тооцохгүй”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 19 дүгээр зүйлийн 19.1 “Шалгагдагч этгээд

аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Түрээсийн гэрээний үүргийн биелэлтийг хангаж ажиллаагүй, өмнөх аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3: Жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 3 харилцагчийн 40.1 сая төгрөгийн авлага, 4 харилцагчийн 44.3 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 4: Хөлсөөр ажиллах гэрээгээр олгосон 38.9 сая төгрөгийн ажлын хөлсөнд НДШ тооцоогүй, шимтгэлийг тайлагнаагүй, өмнөх аудитаар хүргүүлсэн 2025 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 496/A0150053 дугаар албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1 "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитын хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй ажилтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 5: Тайланд онд нээлттэй тендерээр сонгон шалгаруулах 365.0 сая төгрөгийн худалдан авалтад шууд гэрээ байгуулж, өмнөх оны аудитаар хүргүүлсэн 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 497/A0150053 дугаар албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ

биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитын хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй ажилтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 6: Тайлант онд түүврээр 4 тендерийн баримт бичигт хяналт хийхэд үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлийг гарын үсгээр баталгаажуулаагүй, батлагдсан тендерийн баримт бичигт гэрээний тусгай нөхцөлийн маягтын мэдээллийг бөглөөгүй, өгөгдлийн хүснэгтэд заасан шалгуурыг хангаагүй оролцогчдыг шалгаруулсан, шалгарсан оролцогчдод мэдэгдэл хүргүүлэхдээ 2 аж ахуйн нэгжид шалгарсан тухай мэдэгдлийг хүргүүлсэн, бараа нийлүүлэх гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахдаа ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг хавсаргасан, өмнөх оны аудитаар хүргүүлсэн 2025 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 498/A0150053 дугаар албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 “Оролцогч захиалагчийн тогтоосон санхүүгийн чадавхын шаардлагыг хангасан байна”, 17 дугаар зүйлийн 17.4 “Оролцогч захиалагчийн тогтоосон техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна”, 28 дугаар зүйлийн 28.1.1 “хамгийн сайн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгох”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1 “Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитын хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй ажилтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Түрээсийн гэрээтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Ажлын байр түрээсээр ашиглуулах гэрээний дагуу нийт 23 хувь хүн, хуулийн этгээдэд төрийн өмчийн барилгаас түрээслүүлэхдээ ашиглалтын зардлыг тооцон нэхэмжлэн авах талаар гэрээнд тусгаагүй, түрээслэгчийн ашиглалтын зардлыг тус сургууль хариуцан төлж байна. Мөн түрээсийн гэрээнд заасны дагуу байршуулах 22.4 сая төгрөгийн барьцаа төлбөрийг тус сургуулийн дансанд байршуулаагүй, гэрээний биелэлт хангалтгүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай” 2020 оны 49 дүгээр тогтоолын дагуу байгуулсан Түрээсийн гэрээний 3.3 “Түрээслэгч нь гэрээний үүргийн биелэлтийн баталгаа болгож түрээсийн төлбөрийн 1 сарын төлбөртэй тэнцэх хэмжээтэй төлбөрийг хураан авч байршуулах,” 3.8 “Түрээсийн төлбөрт түрээсэлсэн

эд хөрөнгийн ашиглалт /цахилгаан, дулаан, уур, цэвэр бохир ус, интернэт, телефон кабель суваг, хог хаягдал, цэвэрлэгээ, засвар үйлчилгээ/-ний төлбөр хамаарахгүй" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Түрээслэгч хувь хүн, хуулийн этгээдүүдийн ашигласан ашиглалтын зардлыг төлүүлэхээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж, ашиглалтын орлого хүлээн зөвшөөрч бүртгэх мөн барьцаа төлбөрийг гэрээнд заасны дагуу байршуулж, хяналт тавьж ажиллах.

2. Орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт 1:

Сургалтын "SIS" програмд 7 сургуулийн сургалтын төлбөрийн орлогыг бүртгэдэг. Програмын авлага, өглөгийн үлдэгдэл санхүүгийн тайланд тусгагдсан үлдэгдлээс зөрүүтэй байна. Энэ нь санхүүгийн програм, сургалтын "SIS" програмтай холбогдоогүй, сургуулиудын сургалтын орлого нь орлого төвлөрүүлэх дансанд бүрэн ороогүй, бусад дансанд орсон орлогыг гараар оруулдаг зэрэг асуудлууд програмын зорилго хангагдаагүйг харуулж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", 5 дугаар зүйлийн 5.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4. үнэн зөв байх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сургалтын программ болон санхүүгийн программд тусгагдсан сургалтын төлбөрийн авлага болон урьдчилж орсон орлогын дүнгийн зөрүүг харилцагч бүрээр тулган баталгаажуулж, зөрүүг залруулж, тогтмол хяналт тавьж ажиллах.

3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Санхүүгийн тайланд бүртгэлтэй 44.0 сая төгрөгийн өртөгтэй, 0.8 га талбай бүхий "Софт теннисний талбай" нэршилтэй хөрөнгө биетээр байхгүй, уг газар дээр Хөх толбо сонины газар барилга бариад эзэмшиж байгаа бөгөөд 1994 оноос хойш газрын эзэмшлийн маргаантай, одоог хүртэл шийдэгдээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 3 дугаар зүйлийн 3.8 "Газар эзэмших/ашиглах эрх үүсмэгц түүнийг үнэлж, санхүүгийн тайланд бүртгэх саналыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон бусад дээд шатны байгууллагуудад тус асуудлаар дахин хандаж, арга хэмжээ авч ажиллаж шийдвэрлүүлэх.

Илрүүлэлт 2: Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой нийт 4,256 нэр төрлийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг

баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7 дугаар зүйлийн 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлж шийдвэрлүүлэх.

4. Цалин хөлстэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Гэрээгээр ажиллаж байгаа гадаадын иргэнд олгосон 3.8 сая төгрөгийн цалин хөлсийг Монгол ажилтны цалингийн дүнд нэгтгэн НДШ болон ХХОАТ тайлагнасан. Ээлжийн амралтын хоног болон ажлын хоногийг давхардуулан тооцоноос 2 сургуулийн 58 ажилтанд 14.3 сая төгрөгийн цалин хөдөлмөрийн хөлсийг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4. үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Гэрээт ажилтанд олгосон цалин хөлсийг тухайн ажилтны нэрээр татвар болон нийгмийн даатгалын тайланд тайлагнах, ээлжийн амралтын хоног болон ажлын хоногийг давхардуулан цалин хөлсийг олгохгүй байх.

Илрүүлэлт 2: Төрийн болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журамд илүү цаг нь тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна гэсэн заалтыг зөрчиж 18 багшид 83.1 сая төгрөгийн илүү цагийн хөлс тооцон олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4 "Долоо хоногийн ажлын цагийн дээд хязгаар нь 56 цагаас илүүгүй байна. Өдөрт ажиллах илүү цагийн хязгаар нь дөрвөн цагаас илүүгүй байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөдөлмөрийн тухай хуульд заасан илүү цагийн хязгаарыг хэтрүүлэн ажиллуулахгүй байх, илүү цагийн нэмэгдлийг заасан хязгаараас хэтрүүлэн олгохгүй байх мөн хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Санхүү байдлын тайлангийн эргэлтийн хөрөнгийн эхний үлдэгдлийн дүн 2024 оны аудитлагдсан тайлангаас 6.7 сая төгрөгөөр зөрүүтэй;	1	6,742.4			1	6,742.4	1	6,742.4				
2	Санхүүгийн үр дүнгийн тайлангийн хандив, тусламжийн орлогын ангилалд тайлагнах 122.7 сая төгрөгийг нийтлэг татварын бус орлогын ангилалд тайлагнасан;	1	122,744.3			1	122,744.3	1	122,744.3				
3	Санхүүгийн үр дүнгийн тайлангийн улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх ангилалд тайлагнах 0.4 сая төгрөгийг банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж ангилалд тайлагнасан;	1	413.0			1	413.0	1	413.0				
4	Санхүүгийн үр дүнгийн тайлангийн төрөөс иргэдэд олгох нэг удаагийн тэтгэмж, урамшуулал ангилалд тайлагнах 7.0 сая төгрөгийг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал ангилалд тайлагнасан;	1	7,000.0			1	7,000.0	1	7,000.0				
5	Мөнгөн гүйлгээний тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилт ангилалд тайлагнах 352.8 сая төгрөгийг улсын төвлөрсөн төсөв ангилалд тайлагнасан;	1	352,771.4			1	352,771.4	1	352,771.4				
6	Санхүүгийн үр дүнгийн тайланд тусгагдсан элэгдэл, хорогдлын дүн үндсэн хөрөнгийн тодруулга тайлангаас 247.0 сая төгрөгөөр зөрүүтэй;	1	246,985.2	1	246,985.2			1	246,985.2				

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн,
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

7	Санхүү байдлын тайланд тусгагдсан нийт хөрөнгийн дүн өмчийн өөрчлөлтийн тайлангаас 2.1 сая төгрөгөөр зөрүүтэй;	1	2,086.5	1	2,086.5			1	2,086.5				
8	Санхүү байдлын тайланд тусгагдсан цэвэр хөрөнгө, өмчийн дүн өмчийн өөрчлөлтийн тайлангаас 0.5 сая төгрөгөөр зөрүүтэй зэрэг нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 1.27-т Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой гэсэн заалттай нийцээгүй байсныг залруулсан.	1	551.7	1	551.7			1	551.7				
9	Эрдэмтэн, судлаачдын бүтээсэн бүтээлүүдийг Оюуны өмчийн газарт бүртгүүлэн зохиогчийн эрх, патентыг авсан боловч эдгээрийг биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгээгүй.	1		1						1		1	
10	Тайлант онд 3.5 сая төгрөгийн үнэ бүхий сагсны өмсгөл, гар бөмбөгийн хувцас, халаалтын цамц худалдан авсан	1	3,465.0			1	3,465.0			1	3,465.0	1	3,465.0
11	Газар эзэмших эрхийн хугацаа дууссан 2 гэрчилгээний хугацааг сунгаагүй	1				1				1		1	
12	Баталгаажсан цалингийн хүснэгтийг нийгмийн даатгалын тайлан, ХХОАТ-ын тайлантай тулган шалгахад 2 сургуулийн нийгмийн даатгалын тайланг 4.0 сая төгрөгөөр, 1 эмнэлэг, 2 сургуулийн ХХОАТ-ын тайланг 13.1 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан. Мөн татварын хөнгөлөлтийн тооцооллыг хийгээгүйгээс 2 сургууль 1.6 сая төгрөгийн хөнгөлөлтийг дутуу тооцсон	1	18,686.1			1	18,686.1			1	18,686.1	1	18,686.1
13	Санхүүгийн албаны удирдлага, зохион байгуулалтад тавих хяналт сул, ажилтнуудын ажлын ачаалал тэнцвэргүй, санхүүгийн дотоод хяналтын нэг	1		1						1		1	

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн,
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

ажилтантайгаас шалтгаалан дотоод хяналт хангалтгүй хийгддэг, ажилтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, ур чадварыг сайжруулах арга хэмжээ авч ажилдаггүй зэргээс шалтгаалан санхүүгийн албаны үйл ажиллагаанд алдаа, зөрчил ихээхэн гарсан буюу дотоод хяналт сул, хангалтгүй байна.													
Дүн	13	761,445.6	5	249,623.4	8	511,822.2	8	739,294.5	5	22,151.1	5	22,151.1	

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайлант онд “Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох журам”-ын дагуу цалин хөлсийг олгохдоо 4 сургуулийн 6 багшид 2.5 сая төгрөгөөр батлагдсан тушаалаас илүү олгосон байна.	1	2,544.0	1	2,544.0						
2	Ээлжийн амралтын хоног болон ажлын хоногийг давхардуулан тооцож, 2 сургуулийн 3 албан хаагчид 0.6 сая төгрөгийн цалин хөлсийг илүү олгосон, мөн 2024 онд ажлаас чөлөөлөгдсөн 5 багшийн ажилласан хугацааны цалинд 6.5 сая төгрөгийг тайлант оны 6 дугаар сард тооцож олгосон байна.	1	7,170.6	1	7,170.6						
3	Худалдан авалтын зарлагын гүйлгээнээс түүвэрт хамруулан цахим төлбөрийн баримттай тулган баталгаажуулахад 76 харилцагчийн 264.5 сая төгрөгийн гүйлгээ төлбөрийн баримтаар баталгаажаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, өмнөх аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй байна.	1	264,524.2			1	264,524.2				
4	Цайны газрын зориулалттай 2 сургуулийн 581.2 м2 талбайг 2023 оноос эхлэн нэр бүхий нэг харилцагчид түрээсийн гэрээгээр ашиглуулсан боловч түрээсийн төлбөр аваагүй, 2023 онд засварын ажилд зарцуулсан гэх нотлох баримтын бүрдэлгүй 75.0 сая төгрөгийг түрээсийн төлбөрт тооцуулах хүсэлт гаргасныг тус сургуулийн ректорын 2025 оны А/231 дугаар тушаалаар тайлант онд түрээсийн төлбөрт тооцон, зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Мөн 89.0 сая төгрөгийн 145 ширхэг цайны газрын зориулалттай шинэ хөрөнгийг ашиглуулж байгаа боловч гэрээний хавсралтад тусгаагүй, өмнөх оны аудитаар өгсөн “Төрийн өөрийн өмчийн хөрөнгийг түрээслүүлэх гэрээний үүргийн	1	164,062.5			1	164,062.5				

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн,
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

	биелэлтийг хангаж ажиллах” зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.									
5	Жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 3 харилцагчийн 40.1 сая төгрөгийн авлага, 4 харилцагчийн 44.3 сая төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	84,432.0			1	84,432.0			
6	Хөлсөөр ажиллах гэрээгээр олгосон 38.9 сая төгрөгийн ажлын хөлсөнд НДШ тооцоогүй, шимтгэлийг тайлагнаагүй, өмнөх аудитаар хүргүүлсэн 2025 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 496/A0150053 дугаар албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна.	1	38,868.5						1	38,868.5
7	Тайланд онд нээлттэй тендерээр сонгон шалгаруулах 365.0 сая төгрөгийн худалдан авалтад шууд гэрээ байгуулж, өмнөх оны аудитаар хүргүүлсэн 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 497/A0150053 дугаар албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.	1	365,018.3						1	365,018.3
8	Тайлант онд түүврээр 4 тендерийн баримт бичигт хяналт хийхэд үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлийг гарын үсгээр баталгаажуулаагүй, батлагдсан тендерийн баримт бичигт гэрээний тусгай нөхцөлийн маягтын мэдээллийг бөглөөгүй, өгөгдлийн хүснэгтэд заасан шалгуурыг хангаагүй оролцогчдыг шалгаруулсан, шалгарсан оролцогчдод мэдэгдэл хүргүүлэхдээ 2 аж ахуйн нэгжид шалгарсан тухай мэдэгдлийг хүргүүлсэн, бараа нийлүүлэх гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахдаа ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг хавсаргасан, өмнөх оны аудитаар хүргүүлсэн 2025 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 498/A0150053 дугаар албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.	1							1	
9	Ажлын байр түрээсээр ашиглуулах гэрээний дагуу нийт 23 хувь хүн, хуулийн этгээдэд төрийн өмчийн барилгаас түрээслүүлэхдээ ашиглалтын зардлыг тооцон нэхэмжлэн авах талаар гэрээнд тусгаагүй, түрээслэгчийн ашиглалтын зардлыг тус сургууль хариуцан төлж байна. Мөн түрээсийн гэрээнд заасны дагуу байршуулах 22.4 сая төгрөгийн барьцаа төлбөрийг тус сургуулийн дансанд байршуулаагүй, гэрээний биелэлт хангалтгүй байна	1	22,391.8					1	22,391.8	

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн,
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

10	Сургалтын "SIS" програмд 7 сургуулийн сургалтын төлбөрийн орлогыг бүртгэдэг. Програмын авлага, өглөгийн үлдэгдэл санхүүгийн тайланд тусгагдсан үлдэгдлээс зөрүүтэй байна. Энэ нь санхүүгийн програм, сургалтын "SIS" програмтай холбогдоогүй, сургуулиудын сургалтын орлого нь орлого төвлөрүүлэх дансанд бүрэн ороогүй, бусад дансанд орсон орлогыг гараар оруулдаг зэрэг асуудлууд програмын зорилго хангагдаагүйг харуулж байна.	1					1				
11	Санхүүгийн тайланд бүртгэлтэй 44.0 сая төгрөгийн өртөгтэй, 0.8 га талбай бүхий "Софт теннисний талбай" нэршилтэй хөрөнгө биетээр байхгүй, уг газар дээр Хөх толбо сонины газар барилга бариад эзэмшиж байгаа бөгөөд 1994 оноос хойш газрын эзэмшлийн маргаантай, одоог хүртэл шийдэгдээгүй байна.	1	44,000.0				1	44,000.0			
12	Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой нийт 4,256 нэр төрлийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.	1					1				
13	Гэрээгээр ажиллаж байгаа гадаадын иргэнд олгосон 3.8 сая төгрөгийн цалин хөлсийг Монгол ажилтны цалингийн дүнд нэгтгэн НДШ болон ХХОАТ тайлагнасан. Ээлжийн амралтын хоног болон ажлын хоногийг давхардуулан тооцсоноос 2 сургуулийн 58 ажилтанд 14.3 сая төгрөгийн цалин хөдөлмөрийн хөлсийг илүү олгосон байна.	1	18,175.0				1	18,175.0			
14	Төрийн болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журамд илүү цаг нь тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна гэсэн заалтыг зөрчиж 18 багшид 83.1 сая төгрөгийн илүү цагийн хөлс тооцон олгосон байна.	1	83,099.9				1	83,099.9			
	Дүн	14	1,094,286.8	2	9,714.6	3	513,018.7	6	167,666.7	3	403,886.8

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн,
2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
				Албан шаардлага		Хариуцлага тооцох албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
1	Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6,193.3 сая төгрөгийн орлогын 100 гүйлгээ, 7,044.7 сая төгрөгийн зарлагын 145 гүйлгээг мэдээлээгүй, өмнөх оны аудитаар хүргүүлсэн 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 499/A0150053 дугаар албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	13,238,039.5			1	13,238,039.5		
	Дүн	1	13,238,039.5	0	0.0	1	13,238,039.5	0	0.0
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
1	Тендерт шалгарсан 7 оролцогчтой 1,189.8 сая төгрөгийн гэрээ байгуулахдаа 35.7 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгаа гаргуулан аваагүй байна.	1	35,694.8	1	35,694.8				
2	Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл хөтлөх, тендерийг үнэлэх, мэдэгдэл хүргүүлэхдээ холбогдох журам, заалтыг мөрдөж ажиллаагүй, тендерийн баримт бичгийг архивын нэгж үүсгэхдээ шалгарсан оролцогчийн тендерийн баримт бичгийг хавсаргаагүй, тендерт шалгараагүй оролцогчдын нэг ижил баримт материалыг их хэмжээгээр хувилж хавсарган бичиг хэргийн үргүй зардал гаргасан байна.	1						1	
	Дүн	2	35,694.8	1	35,694.8	0	0.0	1	0.0
	Нийт дүн	3	13,273,734.3	1	35,694.8	1	13,238,039.5	1	0.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 189/А0150458

Улаанбаатар хот

САГ - 2026/7/КА - СТА - ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох журмын дагуу олгосон хөлсийг 4 сургуулийн 6 багшид 2,544,000.00 /хоёр сая таван зуун дөчин дөрвөн мянган/ төгрөгөөр батлагдсан тушаалаас илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3 "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"-д заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Илүү тооцож олгосон 2,544,000.00 /хоёр сая таван зуун дөчин дөрвөн мянган/ төгрөгийг Санхүү, эдийн засгийн газрын дарга Т.Булганмаагаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн ректор /Б.Дамдиндорж/-д хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Т.ОДОНЧИМЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 190/АД150458

Улаанбаатар хот

САГ-2026/7/НА-СТА-ТӨҮГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ээлжийн амралтын хоног болон ажлын хоногийг давхардуулан тооцож, 2 сургуулийн 3 албан хаагчид 656,377.00 /зургаан зуун тавин зургаан мянга гурван зуун далан долоон төгрөгийн цалин хөлсийг илүү олгосон, мөн 2024 онд ажлаас чөлөөлөгдсөн 5 багшийн ажилласан хугацааны цалинд 6,514,234.00 /зургаан сая таван зуун арван дөрвөн мянга хоёр зуун гучин дөрвөн төгрөгийг тайлант оны 6 дугаар сард тооцож олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1 "Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3 "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон"-д гэж заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Илүү тооцож олгосон 7,170,611.00 / долоон сая нэг зуун далан мянга зургаан зуун арван нэгэн/ төгрөгийг Санхүү, эдийн засгийн газрын дарга Т.Булганмаагаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн ректор /Б.Дамдиндорж-т хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 9 хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Akt\2026\0316 SAG-37.Docx

1526200255



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 914/А0150458

Улаанбаатар хот

САГ-2026/7/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Жилийн эцсийн санхүүгийн тайлангаар 3 харилцагчийн 40,096,279.00 /дөчин сая ерэн зургаан мянга хоёр зуун далан есөн/ төгрөгийн авлага, 4 харилцагчийн 44,335,738.00 /дөчин дөрвөн сая гурван зуун гучин таван мянга долоон зуун гучин найман/ төгрөгийн өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7 "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн ректор /Б.Дамдиндорж/, Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Б.Зоригтбаатар/, Санхүү, эдийн засгийн газрын дарга /Т.Булганмаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-69.Docx

1526181262



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 915/АД150458

Улаанбаатар хот

САГ-2026/7/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цайны газрын зориулалттай 2 сургуулийн 581.2 м2 талбайг 2023 оноос эхлэн нэр бүхий нэг харилцагчид түрээсийн гэрээгээр ашиглуулсан боловч түрээсийн төлбөр аваагүй, 2023 онд засварын ажилд зарцуулсан гэх нотлох баримтын бүрдэлгүй 75,049,200.00 /далан таван сая дөчин есөн мянга хоёр зуун/ төгрөгийг түрээсийн төлбөрт тооцуулах хүсэлт гаргасныг тус сургуулийн ректорын 2025 оны А/231 дугаар тушаалаар тайлант онд түрээсийн төлбөрт тооцон, зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Мөн 89,013,300.00 /наян есөн сая арван гурван мянга гурван зуун/ төгрөгийн 145 ширхэг цайны газрын зориулалттай шинэ хөрөнгийг ашиглуулж байгаа боловч гэрээний хавсралтад тусгаагүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах" тухай 2020 оны 49 дүгээр тогтоолын хавсралтын 4 "Төрийн өмчийн бүртгэлд байгаа барилга байгууламжид түрээслэгчийн санхүүжилтээр урсгал засвар хийх тохиолдолд түрээсийн төлбөрөөс суутган тооцох асуудлыг засвар хийхээс өмнө төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ", Түрээсийн гэрээний 1.6 "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгөнд зөвшөөрөлгүйгээр хөрөнгө оруулалт хийхийг хориглох, зайлшгүй тохиолдолд төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зөвшөөрөл авах бөгөөд зөвшөөрөлгүй хөрөнгө оруулалт, их засвар хийсэн тохиолдолд зардлыг төрөөс хариуцахгүй", 6.4 "Түрээсэлсэн эд хөрөнгөнд түрээслэгч урсгал зардлыг өөрийн хөрөнгөөр хийж болно. Урсгал засвар гэдэгт барилгын их засвар хооронд барилга ашиглалтыг сайжруулахаар хийгдэж буй засварыг ойлгоно, Урсгал засварыг түрээсийн төлбөрт суутган тооцохгүй", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 19 дүгээр зүйлийн 19.1 "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах, асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зөвлөмжийн дагуу зохих ёсоор арга хэмжээ авч, залруулах ажлыг зохион байгуулсан байна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.3 "өмч, хөрөнгийг бусдад зүй бусаар ашиглуулсан"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-69.Docx

1526181248

1. Өмнөх аудитын шийдвэрийг хэрэгжүүлээгүй, түрээсийн гэрээний үүргийн биелэлтийг хангаж ажиллахгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн ректор /Б.Дамдиндорж/, Хангамж, үйлчилгээний газрын дарга /Б.Бат-Амгалан/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Т.ОДОНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 916/АО 150458

Улаанбаатар хот

САГ-2026/7/НА-СТА-ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авалтын зарлагын гүйлгээнээс түүвэрт хамруулан цахим төлбөрийн баримттай тулган баталгаажуулахад 76 харилцагчийн 264,524,251.00 /хоёр зуун жаран дөрвөн сая таван зуун хорин дөрвөн мянга хоёр зуун тавин нэгэн/ төгрөгийн гүйлгээ төлбөрийн баримтаар баталгаажаагүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, өмнөх аудитаар өгсөн зөвлөмж хэрэгжээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1 “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй”-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авалтыг төлбөрийн баримтаар иж бүрэн баримтжуулахгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн ректор /Б.Дамдиндорж/, ерөнхий нягтлан бодогч /Ш.Төгсбаяр/ нарт даалгав.

АНХАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230



Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-69.Docx

1526181240



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 917/АД150458

Улаанбаатар хот

САГ-2026/7/НА - СТА - ТӨҮГ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тендерт шалгарсан 7 оролцогчтой 1,189,826,400.00 /нэг тэрбум нэг зуун наян есөн сая найман зуун хорин зургаан мянга дөрвөн зуун/ төгрөгийн гэрээ байгуулахдаа 35,694,800.00 /гучин таван сая зургаан зуун ерэн дөрвөн мянга найман зуун/ төгрөгийн гүйцэтгэлийн баталгаа гаргуулан аваагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 "Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Гүйцэтгэлийн баталгаа гаргуулан авдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн ректор /Б.Дамдиндорж/, Хангамж, үйлчилгээний газрын дарга /Б.Бат-Амгалан/, Санхүү, эдийн засгийн газрын дарга /Т.Булганмаа/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Т.ОДОНЧИМЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 918/А015 0458

Улаанбаатар хот

САГ-2026/7/НА - СТА - ТӨҮГ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд түүврээр 4 тендерийн баримт бичигт хяналт хэрэгжүүлэхэд үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлийг гарын үсгээр баталгаажуулаагүй, батлагдсан тендерийн баримт бичигт гэрээний тусгай нөхцөлийн маягтын мэдээллийг бөглөөгүй, өгөгдлийн хүснэгтэд заасан шалгуурыг хангаагүй оролцогчдыг шалгаруулсан, шалгарсан оролцогчдод мэдэгдэл хүргүүлэхдээ 2 аж ахуйн нэгжид шалгарсан тухай мэдэгдлийг хүргүүлсэн, бараа нийлүүлэх гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахдаа ажил гүйцэтгэх тендер шалгаруулалтын жишиг баримт бичиг хавсаргасан, өмнөх оны аудитаар хүргүүлсэн 2025 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 498/А0150053 дугаар албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 "Оролцогч захиалагчийн тогтоосон санхүүгийн чадавхын шаардлагыг хангасан байна", 17 дугаар зүйлийн 17.4 "Оролцогч захиалагчийн тогтоосон техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна", 28 дугаар зүйлийн 28.1.1 "хамгийн сайн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгох", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1 "Шалгагддаг этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах.." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй Хангамж үйлчилгээний газрын дарга /Б.Бат-Амгалан/, менежер /Ө.Зулцэцэг/ нарт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2026 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар¹-т ирүүлэхийг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн ректор /Б.Дамдиндорж/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230



Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-69.Docx

1526181258



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 919/A0150458

Улаанбаатар хот

САГ-2026/7/НА-СТА-ТӨҮГ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайланд онд нээлттэй тендерээр сонгон шалгаруулах 365,018,282.00 /гурван зуун жаран таван сая арван найман мянга хоёр зуун наян хоёр/ төгрөгийн худалдан авалтад шууд гэрээ байгуулж, өмнөх оны аудитаар хүргүүлсэн 2025 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 497/A0150053 дугаар албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1 "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах.." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй Санхүү, эдийн засаг хариуцсан проректор /С.Нансалмаа/-д хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2026 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн ректор /Б.Дамдиндорж/-д даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Т.ОДОНЧИМЭГ

9006109
ATA16087
9025081411

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-69.Docx

1526181256



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 920/А0150458

Улаанбаатар хот

САГ-2026/7/НА-СТА-ТӨҮГ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөлсөөр ажиллах гэрээгээр олгосон 38,868,500.00 /гучин найман сая найман зуун жаран найман мянга таван зуун/ төгрөгийн ажлын хөлсөнд нийгмийн даатгалын шимтгэл тооцоогүй, шимтгэлийг тайлагнаагүй, өмнөх аудитаар хүргүүлсэн 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 496/А0150053 дугаар албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19.1 "Шалгагдагч этгээд аудитаар өгсөн зөрчил дутагдлыг арилгах.." гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй Санхүү, эдийн засгийн газрын дарга /Т.Булганмаа/-д хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2026 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар-т ирүүлэхийг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн ректор /Б.Дамдиндорж/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Т.ОДОНЧИМЭГ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 921/АД150458

Улаанбаатар хот

САГ-2026/7/НА-СТА - ТӨҮГ

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 6,193,311,500.00 /зургаан тэрбум нэг зуун ерэн гурван сая гурван зуун арван нэгэн мянга таван зуун/ төгрөгийн орлогын 100 гүйлгээ, 7,044,728,000.00 /долоон тэрбум дөчин дөрвөн сая долоон зуун хорин найман мянган/ төгрөгийн зарлагын 145 гүйлгээг мэдээлээгүй, өмнөх оны аудитаар хүргүүлсэн 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 499/АД150053 дугаар албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2 “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралт “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2.10 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ”-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд иж бүрэн, үнэн зөв байршуулаагүй, өмнөх аудитаар хүргүүлсэн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга /Б.Зоригтбаатар/-т хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2026 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газар¹-т ирүүлэхийг Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн ректор /Б.Дамдиндорж/-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9026109
ATA16087
9025081411

Z:\Alban Shaardlaga\2026\0316 SAG-69.Docx

1526181252